

**“МАНДАЛ ДИЖИТАЛ КРЕДИТ ББСБ” ХХК-ИЙН  
ТУЗ-ИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ,  
ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ**

**Улаанбаатар хот  
2023 он**

## **АГУУЛГА**

Нэг. Нийтлэг үндэслэл .....	1
Хоёр. Мэдээлэл, түүний ангилал зориулалт .....	1
Гурав. Хугацаат тайлагналын мэдээлэл .....	1
Дөрөв. Тухай бүр нийтэд мэдээлэх мэдээлэл .....	4
Тав. Нууц мэдээлэл.....	7
Зургаа. Мэдээллийг боловсруулах журам .....	7
Долоо. Мэдээллийг тайлагнах, нийтэд хүргэх журам.....	8
Найм. Дотоод мэдээлэл эзэмшин, түүний арилжаанд оролцох журам .....	9
Ес. Хариуцлага .....	11
Арав. Бусад зүйл .....	11

## МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. “МАНДАЛ ДИЖИТАЛ КРЕДИТ ББСБ” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь Компанийн хувьцаа эзэмшигчид болон сангийн үйлчилгээ авч буй нэгж эрх эзэмшигчид (цаашид “Оролцогч бусад этгээдэд” гэх) Компани болон үүсгэн байгуулсан сангийн талаарх үнэн зөв мэдээллийг тогтмол хүргэх, Компани нь хууль тогтоомж, дүрэм журамд заасан болон бусад чухал ач холбогдол бүхий мэдээллийг нээлттэй болгох, хувьцаа эзэмшигчдийн зүгээс Компанийг удирдах үйл ажиллагаанд оролцох эрхээ зохистойгоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд оршино.
- 1.2. Энэхүү Журмыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:
  - 1.2.1. Тухайн мэдээллийн ач холбогдол, Компанийн бизнест нөлөөлөх байдлаас хамааруулан мэдээллийг тогтмол давтамжтай боловсруулах, шинэчлэх;
  - 1.2.2. Хууль тогтоомж, дүрэм, журамд заасан мэдээллийг нийтэд хүргэх шаардлага, ач холбогдолтой нь уялдуулан тогтсон цаг хугацаанд нь олон нийт, холбогдох эрх бүхий байгууллагад хүргэх;
  - 1.2.3. Компанийн хувьцаа эзэмшигчид болон оролцогч бусад этгээдэд тэгш хүртээмжтэй байх;
  - 1.2.4. Үнэн зөв, тодорхой, ойлгомжтой, бүрэн хэмжээтэй байх;
  - 1.2.5. Компанийн бизнесийн эрх ашиг, нээлттэй байх зарчим хоёрын зохистой тэнцвэрийг хангасан байх.

### ХОЁР. МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙ АНГИЛАЛ ЗОРИУЛАЛТ

- 2.1. Компаниас боловсруулан гаргаж буй мэдээлэлд Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, санхүүгийн тайлан болон хөрөнгө оруулагчид эсвэл оролцогч бусад этгээд мэдвэл зохих бусад мэдээллүүд багтана.
- 2.2. Компаниас боловсруулан гаргаж буй мэдээллүүдийг түүний зориулалт, нууцлалын шаардлага зэргийг харгалзан дараах үндсэн ангилалд хуваана. Үүнд:
  - 2.2.1. Хугацаат тайлагналын мэдээлэл (1 дүгээр зэрэглэл);
  - 2.2.2. Тухай бүр нийтэд мэдээлэх мэдээлэл (2 дугаар зэрэглэл);
  - 2.2.3. Нууц мэдээлэл (3 дугаар зэрэглэл).

### ГУРАВ. ХУГАЦААТ ТАЙЛАГНАЛЫН МЭДЭЭЛЭЛ

- 3.1. Хугацаат тайлагналын мэдээлэл гэж Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр олон нийтэд тогтмол түгээхийг үүрэг болгосон мэдээллийг ойлгох ба дараах хэлбэртэй байна. Үүнд:
  - 3.1.1. Жилийн үйл ажиллагааны тайлан;
  - 3.1.2. Хагас жилийн үйл ажиллагааны тайлан.
- 3.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлагналын мэдээлэл нь дараах төрлийн мэдээллийг агуулсан байна. Үүнд:
  - 3.2.1. Компанийн тайлант хугацааны санхүүгийн мэдээлэл:
    - 3.2.1.1. Компанийн жилийн санхүүгийн тайлан тэнцэл, тодруулга;

- 3.2.1.2. Аудитын компаниас санхүүгийн тайланд орсон мэдээлэл нь үнэн зөв, олон улсын стандартын дагуу тайлагнасныг баталж, үйлчилгээ үзүүлсэн этгээдтэй сонирхлын зөрчил үүсгээгүй, хараат бусаар ажилласан талаарх баталгаат захидал;
- 3.2.1.3. Компанийн санхүүгийн жилд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;
- 3.2.1.4. Компанийн жилийн санхүүгийн тайлангийн мэдээлэлд хөрөнгө оруулагч болон хувьцаа эзэмшигч хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай санхүүгийн нөхцөл байдал, төлбөрийн ба хөрвөх чадварыг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл.
- 3.2.2. Компанийн гүйцэтгэх удирдлагаас гаргах тайлангийн мэдээлэл: Компани нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, ашигт ажиллагааг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг мэдээллийг тусгасан тайланг дараах агуулгын хүрээнд гаргана. Үүнд:
- 3.2.2.1. Үйл ажиллагааны үр дүнгийн мэдээлэл: тайлант жилд орлогод нөлөөлсөн гадаад, дотоод орчны нөлөөллийг тусгасан дүгнэлт, мэдээлэл;
- 3.2.2.2. Хөрвөх чадварын болон санхүүгийн нөөц, боломжийн мэдээлэл: Компанийн богино, дунд, урт хугацааны төлбөрийн болон хөрвөх чадварын үзүүлэлтүүд, Компанийн өөрийн санхүүгийн нөөцөөр бизнесийн үйл ажиллагаанаас бий болсон өр төлбөрийг бүрэн хариуцах боломж, шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод санхүүжилтийн эх үүсвэрээс санхүүжилт татах боломжтой эсэх дүгнэлт, мэдээлэл;
- 3.2.2.3. Компанийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл, төрөлжилт, дээрх өөрчлөлтөд Компанийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл;
- 3.2.2.4. Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаарх товч мэдээлэл.
- 3.2.3. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл:
- 3.2.3.1. Компанийн санхүүгийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл, дээрх хэлцлийг хийснээр гарах үр дүн;
- 3.2.3.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл;
- 3.2.3.3. Сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл.
- 3.2.4. Цалин урамшууллын мэдээлэл:
- 3.2.4.1. Санхүүгийн жилд ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагад бодитоор олгосон цалин, урамшуулал, шагнал, ТУЗ-ийн дэргэдэх Хороодын гишүүний хувиар, эсвэл Компанитай хийсэн бусад гэрээ, хэлцлийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын цалин хөлсийг оруулсан дэлгэрэнгүй задаргаа бүхий мэдээлэл;
- 3.2.4.2. Компанийн эрх бүхий албан тушаалтны эзэмшдэг хувьцаанд хөрвөх

- опцион болон хувьцааны тоо ширхэг, өөр бусад урт хугацааны шагнал, урамшуулал болон тэдгээрийн хэрэгжих нөхцөлийн талаарх мэдээлэл;
- 3.2.4.3. Компаниас баримталдаг нөхөн олговор, урамшуулал, шагналын талаарх баримталдаг бодлого.
- 3.2.5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл:
- 3.2.5.1. ТУЗ-ийн дарга, ердийн, хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагын мэдээлэл;
- 3.2.5.2. Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;
- 3.2.5.3. ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, хариуцлага, гишүүдийн нэр, боловсрол, ажлын туршлага;
- 3.2.5.4. Ёс зүйн дүрэм, эрсдэлийн удирдлагын хэрэгжилт;
- 3.2.5.5. ТУЗ болон түүний дэргэдэх хороодын ажлын тайланг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын дүгнэлт;
- 3.2.5.6. Гүйцэтгэх удирдлагын ажлын тайланг хэлэлцсэн ТУЗ-ийн дүгнэлт;
- 3.2.5.7. Дотоод аудитын ажлын тайланг хэлэлцсэн ТУЗ-ийн дүгнэлт, мэдээлэл;
- 3.2.5.8. СЗХ-оос баталсан “Компанийн засаглалын кодекс”-т заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, заавар;
- 3.2.5.9. Эрсдэлийн удирдлага хариуцсан хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүн;
- 3.2.5.10. Шаардлагатай тохиолдолд СЗХ-оос баталсан үнэлгээний аргачлалын дагуу өөрийн Компанийн засаглалыг үнэлсэн үнэлгээний тайлан.
- 3.2.6. Компанийн засаглалын зарчмуудын хэрэгжилтийн мэдээлэл:
- 3.2.6.1. “Компанийн засаглалын кодекс”-т заасан Компанийн засаглалын зарчмуудын хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээлэл, үнэлгээ;
- 3.2.7. Эрсдэлийн мэдээлэл:
- 3.2.7.1. Арилжаанд бий болсон зах зээлийн эрсдэлийг удирдах чиглэлээр гаргасан үүсмэл санхүүгийн болон бусад хэрэгслийн мэдээлэл, зах зээлийн эрсдэлийг тооцдог арга аргачлал, эрсдэлийг удирдах стратегийн талаарх мэдээлэл;
- 3.2.7.2. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг удирдах стратегийн талаарх мэдээлэл.
- 3.2.8. Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл:
- 3.2.8.1. Компанийн тайлант жил дэх эцсийн өмчлөгч болон нөлөө бүхий, хяналтын багц эзэмшигч гадаад дотоодын иргэн, аж ахуйн нэгжийн нэрс, хувьцааны тоо ширхэг, төвлөрлийн мэдээлэл;
- 3.2.8.2. Компанийн хувьцаа эзэмшдэг охин, хараат компанийн мэдээлэл, тайлант хугацаанд Компанийн тухай хуульд заасны дагуу шаардах эрхээ хэрэгжүүлэн хувьцаа худалдсан хувьцаа эзэмшигчийн тоо, үнийн дүнгийн мэдээлэл.
- 3.2.9. Ногдол ашгийн мэдээлэл:
- 3.2.9.1. Компанийн ногдол ашгийн бодлого, тухайн жилд хуваарилсан ногдол ашгийн хэмжээ, тараах хэлбэр, ногдол ашиг хуваарилахгүй тохиолдолд энэ талаарх үндэслэл, өмнөх жилд ногдол ашиг хуваарилсан тохиолдолд түүний тараалтын тайлан, мэдээлэл.
- 3.2.10. Нийгмийн хариуцлагын мэдээлэл:
- 3.2.10.1. Компаниас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр

хийгдсэн ажлын тайлан, мэдээлэл.

3.2.11. Бусад шаардлагатай мэдээлэл:

3.2.11.1. Компани шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

- 3.3. Компанийн хагас жилийн үйл ажиллагааны тайланд хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай Компанийн санхүү, үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн шинжтэй мэдээлэл агуулагдах бөгөөд дараах төрөлтэй байна. Үүнд:
- 3.3.1. Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаргасан хагас жилийн санхүүгийн тайлан, тодруулгын мэдээлэл;
  - 3.3.2. Тайлант хугацаанд Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан;
  - 3.3.3. Тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл;
  - 3.3.4. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооноос хагас жилийн тайланг хэлэлцэж, тайланд тусгасан мэдээлэл үнэн зөв талаарх дүгнэлт;
  - 3.3.5. Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний мэдээлэл;
  - 3.3.6. Компани нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл;
  - 3.3.7. ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны эзэмшиж буй Компанийн хувьцааны талаарх мэдээлэл, Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, дотоод аудитын ажлын тайланг хэлэлцсэн ТУЗ-ийн дүгнэлт, гүйцэтгэх удирдлагын ажлын тайланг хэлэлцсэн ТУЗ-ийн дүгнэлт, Компанийн эцсийн өмчлөгч болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл.
- 3.4. Компани энэхүү Журмын 3 дугаар зүйлийн 3.2 болон 3.3 дахь хэсэгт заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж Монголын хөрөнгийн бирж (цаашид "МХБ" гэх)-д хүргүүлнэ. Үүнд:
- 3.4.1. Компанийн бүтэц (толгой, охин, хараат, зэргэлдээ компани, тэдгээрийн хувь эзэмшлийн талаар), холбоотой талуудын санхүүгийн гүйлгээний талаарх мэдээлэл;
  - 3.4.2. Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 61 дүгээр зүйлийн 61.1.3, 61.1.4 дэх хэсэгт заасан нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлж, энэхүү нөхцөл байдал үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл;
  - 3.4.3. Тайлант хугацаанд эргүүлэн худалдан авсан халаасны хувьцааны тоо, ширхэг, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсэн, үнэт цаасаар урамшуулал олгосон талаарх мэдээлэл.

### **ДӨРӨВ. ТУХАЙ БҮР НИЙТЭД МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЭЛ**

- 4.1. Тухай бүр нийтэд мэдээлэх мэдээлэл гэж Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр олон нийтэд түгээхээр тогтсон, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад үндэслэл бүхий шийдвэр гаргахад шаардлагатай, Компанийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон ажил хэрэг, үйл ажиллагаатай холбоотой цогц мэдээллийг ойлгоно. Энэхүү мэдээллийг холбогдох хууль СЗХ-ны журмын хүрээнд заавал олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээгээгүй

нөхцөлд тухай бүр мэдээлэх эсэхийг Гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ. Үүнд:

- 4.1.1. Компанийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, бизнест шууд нөлөө үзүүлэхүйц гэрээ, хэлцэл байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, дуусгавар болгох, татгалзах, гэрээний хугацаа дууссантай холбоотой мэдээллийг олон нийтэд мэдээлэх бөгөөд мэдээлэлд гэрээг байгуулсан огноо, гэрээний нөхцөл, гэрээнд оролцогч талуудын эрх үүрэг, гэрээний нэг талд түүний охин хараат компани оролцсон эсэх талаарх мэдээлэл;
- 4.1.2. Шүүх, прокурор, төрийн эрх бүхий байгууллагаас Компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний хараат, охин компанийг хариуцагчаар татаж, захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн, шүүхээс дампуурлын тухай хууль тогтоомжийн дагуу эрх хүлээн авагч томилогдсон талаарх мэдээлэл;
- 4.1.3. Компани нийт активын 25 хувь ба түүнээс дээш хэмжээтэй тэнцэх үл хөдлөх хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалсан эсхүл бусад компанийн хяналтын багц худалдан авсан талаарх мэдээлэл, холбогдох гэрээ, хэлцэл;
- 4.1.4. Компанийн санхүүгийн байдлын гадуурх бүртгэлтэй холбоотой санхүүгийн болон санхүүгийн бус эрх үүрэг бий болгосон гэрээ, хэлцэл, гүйлгээтэй холбоотой мэдээллийг мэдээлэх бөгөөд мэдээлэлд гэрээ, хэлцлийн хугацаа, үнийн дүн, төлбөрийн нөхцөл, гүйлгээний товч утга, богино болон урт хугацаат түрээсийн гэрээнээс бий болсон эрх үүрэг, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай холбоотой мэдээлэл;
- 4.1.5. Компанийн эрх бүхий этгээдээс СТОУС-ын дагуу компанийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзэн дахин үнэлгээ хийхээр шийдвэрлэсэн тохиолдолд холбогдох шийдвэр, шийдвэрийг гаргах болсон нөхцөл, шаардлага, үнэ цэнэ нь буурсан хөрөнгө болон хөрөнгийн үнэ цэний бууралтын хэмжээ эсхүл хязгаарын тооцоолол;
- 4.1.6. Арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн шалгуурыг хангахгүй болсонтой холбогдуулан бүртгэлийн ангилал бууруулах, эсхүл бүртгэлээс хасагдах мэдэгдэл хүлээн авсан тухай мэдээлэл. Хэрэв Компани нь арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд үлдэх хүсэлт гаргасан бол уг хүсэлт хүргүүлсэн огноо болон дээрх мэдэгдлийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ, бүртгэлтэй хугацаанд биелүүлсэн болон хангаж чадаагүй гэрээгээр хүлээсэн үүргийн талаарх мэдээлэл;
- 4.1.7. Компанийн тайланд аудит хийж буй хараат бус нягтлан бодогч ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан зэрэг шалтгаанаар өөрчлөгдсөн тохиолдолд энэ талаар мэдэгдэх бөгөөд нягтлан бодогчоос Компанийн дээрх мэдээлэлтэй санал нийлж буй эсэх талаар мэдэгдлийг хавсаргана, эсхүл шинэ хараат бус нягтлан бодогч ажилд орсон бол ажилд томилсон шийдвэр, шинэ нягтлан бодогчийн Компанийн санхүүгийн тайлантай холбоотой гаргасан санал, дүгнэлт, зөвлөгөө;
- 4.1.8. Компанийн эрх бүхий этгээдээс компанийн өмнөх жилүүдийн санхүүгийн тайланд алдаа гарсан гэж үзсэн бол алдаатай санхүүгийн тайлангууд, алдаа гарсан гэж үзэх үндэслэл, нөхцөл, компанийн аудитын хороо, эсхүл эрх бүхий албан тушаалтан энэ талаар хараат бус нягтлан бодогчтой **ХЭЛЭЛЦСЭН** эсэх талаар мэдээлэл, хараат бус нягтлан бодогчоос Компанид санхүүгийн тайлангийн алдаатай байдлын талаар мэдэгдсэн бол нягтлан бодогчоос өгсөн мэдэгдлийн огноо, товч агуулгын талаарх мэдээлэл;
- 4.1.9. Компанийн хяналтын багцыг бусад этгээдэд шилжүүлэхтэй холбоотой мэдээлэл: Компанийн хяналтын хувьцааг худалдах болон шилжүүлэхээр хийгдсэн хэлцлийн хугацаа, товч танилцуулга, зорилго, төлбөр төлөх хэлбэр, төлбөрийн зарцуулалт, худалдан авагчийн товч танилцуулга, хувьцаа

- эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, өмнөх хувьцаа эзэмшигчдийн хувь хэмжээний бууралтын талаарх мэдээлэл;
- 4.1.10. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ТУЗ-ийн дарга, гишүүдийг томилж, чөлөөлөхтэй холбоотой мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн дарга, гишүүдийг томилж, огцруулж, нөхөн томилох, эсвэл татгалзсан хурлын тэмдэглэл, шийдвэрийн агуулга, огноо, ТУЗ-өөс гүйцэтгэх удирдлагыг томилж, чөлөөлсөн талаарх мэдээлэл;
  - 4.1.11. Эрсдэлийн хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаарх мэдээлэл;
  - 4.1.12. Байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлаар оролцогч талуудтай харилцах тухай стратегийн мэдээлэл, тайлан;
  - 4.1.13. Компанийн дүрэмд орсон өөрчлөлт: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж баталсан дүрмийн өөрчлөлтийг СЗХ, төрийн холбогдох байгууллагад бүртгүүлсэн огноо, дугаар, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, эцэслэсэн дүрэм;
  - 4.1.14. Компанийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн, гарсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тухайн ажиллаж байсан компанийн хувьцааг бирж болон биржийн бус зах зээл дээр худалдах, худалдан авахыг хориглосон арга хэмжээ болон үүнтэй холбогдуулан компанийн ТУЗ-өөс гарсан шийдвэр, арга хэмжээний талаарх мэдээлэл;
  - 4.1.15. Компанийн ёс зүйн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, зарим хэсгийг түр түдгэлзүүлсэн талаарх мэдээлэл;
  - 4.1.16. Үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулсан, үндсэн болон шинэ бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах болон барааны тэмдэг эзэмших эрх хүчингүй болсон эсхүл цуцлагдсан талаарх мэдээлэл;
  - 4.1.17. Оноосон нэр, үндсэн захиргаа, оршин байх хаяг байршил өөрчлөгдсөн талаар, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, эсхүл татан буулгах талаарх мэдээлэл;
  - 4.1.18. Үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон талаарх мэдээлэл;
  - 4.1.19. Компани төлбөрийн чадваргүй болох, Компанийг татан буулгах чиглэлээр гаргасан шийдвэр.
- 4.2. Компани нь СЗХ-ны журам, холбогдох хуульд заасан тухай бүр мэдээлэх мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлэх үүрэгтэй бөгөөд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж буй хамтын сангуудын хувьд МХБ-н мэдээлэх журмын баримтлан холбогдох мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргүүлнэ.

## **ТАВ. НУУЦ МЭДЭЭЛЭЛ**

- 5.1. Компанийн “Нууцын тухай журам”-д заасан болон Байгууллагын нууцын тухай хууль болон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хамгаалагдсан мэдээллийг Нууц мэдээлэл гэх ба тус мэдээллийг шүүх, цагдаа, татвар зэрэг төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд задруулахыг хориглоно.

## **ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ**



- 6.1. Хугацаат тайлагналын мэдээлэл болон тухай бүр нийтэд мэдээлэх мэдээллийг ТУЗ болон Компанийн тухайн асуудлаар харьяалсан чиг үүрэг бүхий албан тушаалтан, алба, нэгж, хэсгийн дарга хариуцан хамтын ажиллагааны үндсэн дээр үнэн, зөв эх сурвалжуудыг ашиглан Монгол хэл дээр бичгийн болон тоон хэлбэрээр боловсруулж, Гүйцэтгэх удирдлагад болон Гүйцэтгэх удирдлагын томилсон мэдээллийг нийтэд түгээх эрх бүхий албан тушаалтанд шуурхай хүргэнэ. Шаардлагатай тохиолдолд эсхүл сайн дурын үндсэн дээр мэдээллийг Англи хэл дээр үйлдэж болно.
- 6.2. Санхүүгийн тайлагналыг хуульд заасан хугацаа, агуулга, хэлбэрээр бодитоор илэрхийлж, хангалттай, бүрэн тайлбарыг хавсаргана,
- 6.3. Санхүүгийн бус тайланд байгаль орчин, нийгэм, засаглалын хүчин зүйлсээс гадна компанийн стратегийн зорилтуудад хүрэхэд ямар үр дүн гаргаж буй талаарх мэдээллийг багтаана.
- 6.4. Мэдээллийн үнэн бодит байдлыг мэдээлэл гаргасан алба нэгж хэсгийн дарга болон Гүйцэтгэх удирдлага, Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон мэдээллийг түгээх эрх бүхий ажилтан хариуцах бөгөөд Компанийн Дотоод хяналт хариуцсан алба хяналт тавина.
- 6.5. Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (цаашид “Нарийн бичгийн дарга” гэх) нь Хугацаат тайлагналын мэдээлэл ба тухай бүр нийтэд мэдээлэх мэдээллийг тухай бүр холбогдох эрх бүхий байгууллагад болон өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулна.
- 6.8. Компани нь сайн дурын үндсэн дээр байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээр тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааны мэдээллийг МХБ-ийн холбогдох журмын дагуу боловсруулж, жилийн үйл ажиллагааны тайлангийн хамт жилд 1 удаа хүргүүлж болно.
- 6.9. Мэдээлэл боловсруулагч болон олж авсан ажилтан, хувь хүн нь мэдээллийг энэхүү журамд заасан нөхцөл, хугацаагаар нийтэд мэдээлэх хүртэл мэдээллийн нууцлалыг хариуцан ажиллах үүрэгтэй.

## **ДОЛОО. МЭДЭЭЛЛИЙГ ТАЙЛАГНАХ, НИЙТЭД ХҮРГЭХ ЖУРАМ**

- 7.1. Нарийн бичгийн дарга нь Хугацаат тайлагналын мэдээлэл ба тухай бүр нийтэд мэдээлэх мэдээллийг тайлагнах, нийтэд хүргэхэд дараах журмыг баримтална.
- 7.2. Хугацаат тайлагналын мэдээллүүдийг компанийн цахим хуудсанд байрлуулсан хугацаанаас хойш 5 жил хадгалагдах боломжтойгоор программ хангамжийг тохируулсан байна.
- 7.3. Тухай бүр нийтэд мэдээлэх мэдээллүүдийн эх хувь, цаасан болон цахим баримтуудыг Компанийн Архив албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу бүртгэж хадгална.
- 7.4. Компанийн цахим хуудсанд энэ Журамд зааснаас гадна дараах мэдээллийг заавал байршуулна. Үүнд:
  - 7.4.1. Компанийн засаглалын журмууд;
  - 7.4.2. Холбоо барих, харилцах этгээдийн талаарх мэдээлэл;
  - 7.4.3. ТУЗ-ийн дарга, гишүүд болон гүйцэтгэх удирдлагын товч намтар;
  - 7.4.4. Сүүлийн тав хүртэлх жилийн санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайлан;
  - 7.4.5. Үнэт цаасны арилжаа эрхлэгч болон зохицуулагч байгууллагад хүргүүлсэн, тэдгээрээс хүлээн авсан чухал шийдвэр, мэдэгдэл;
  - 7.4.6. ХЭХ-ын зар, шийдвэр.
  - 7.4.7. Компанийн бүтэц, түүх, бизнесийн үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл;

- 7.4.8. ХЭХ хуралдуулах, ногдол ашиг тараах зэрэг томоохон үйл явдлын хуанли;
  - 7.4.9. Гаргасан үнэт цаасны төрөл, холбогдох эрх, тэдгээрийн арилжааны үнэ ханшийн түүхэн мэдээлэл;
  - 7.4.10. Хэвлэл мэдээлэлд гаргасан мэдэгдэл;
  - 7.4.11. Хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах болон үнэт цаасны бүртгэл хариуцсан этгээдийн нэр, холбоо барих мэдээлэл.
- 7.5. Компаниас хүргүүлсэн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөлт оруулах болсон шалтгаан, тайлбарыг тодорхой бичиж, албан байдлаар хүргүүлнэ.

## **НАЙМ. ДОТООД МЭДЭЭЛЭЛ ЭЗЭМШИГЧ, ТҮҮНИЙ АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЖУРАМ**

- 8.1. Дотоод мэдээлэл гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 76 дугаар зүйлд зааснаар үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх нийтийн хүртээл болоогүй мэдээллийг ойлгох ба нийтэд нээлттэй мэдээлэлд үндэслэн хийсэн дүн шинжилгээ нь үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх боломжтой байсан ч түүнийг дотоод мэдээлэл гэж үзэхгүй. СЗХ-ны 2019 оны 72 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам”-ын 2.1-д нарийвчлан заасан мэдээллийг Компанийн дотоод мэдээлэл (цаашид “Дотоод мэдээлэл” гэх)-д тооцно.
- 8.2. Дараах этгээдийг Компанийн дотоод мэдээлэл эзэмшигч (цаашид “Дотоод мэдээлэл эзэмшигч” гэх) гэж үзнэ:
- 8.2.1. Компанийн, түүний охин, хараат компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтан болон тэдгээрийн холбогдох этгээд;
  - 8.2.2. Компанийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны хяналтын багцыг эзэмшигч;
  - 8.2.3. Албан үүргээ хэрэгжүүлэх, гэрээ, хэлцлийн бэлтгэл болон түүнийг байгуулах, гүйцэтгэх үе шатанд дотоод мэдээллийг олж авсан СЗХ, МХБ, Үнэт цаасны зах зээлд оролцогч зохицуулалттай этгээдийн ажилтан болон тэдгээрийн холбогдох этгээд;
  - 8.2.4. Компанийн хараат бус зөвлөхүүд болох хуульч, аудитор, үнэлгээ тогтоогч, бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын эрх бүхий албан тушаалтан, ажилтан;
  - 8.2.5. Компанийн хөрөнгө, өр төлбөр, хувьцаа эзэмшигчдийн өмч болон Компанийн үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ, хэлцлийн бэлтгэл болон түүнийг байгуулах, гүйцэтгэх үе шатанд дотоод мэдээллийг олж авсан этгээд, тэдгээр нь хуулийн этгээд бол түүний эрх бүхий албан тушаалтан;
  - 8.2.6. Энэ Журмын 8 дугаар зүйлийн 8.2.1-8.2.5 дахь хэсэгт заасан үүрэг, албан тушаал өөрчлөгдсөнөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрөөгүй байгаа этгээд.
- 8.3. Дотоод мэдээлэл эзэмшигч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 8.3.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах;
  - 8.3.2. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах;
  - 8.3.3. Үнэт цаасны зах зээлийн талаар нийтэд мэдээлэх, холбогдох мэдээ мэдээллийг зохих хууль тогтоомжийн дагуу хөрөнгө оруулагчдад хүргэх;
  - 8.3.4. Үнэт цаасны зах зээл дээр өөрт оногдсон ажил үүргийг ил тод, шударга гүйцэтгэх;
  - 8.3.5. Байгууллага, иргэдээс гаргасан санал, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх;
  - 8.3.6. Дотоод мэдээллийн нууцыг хадгалах.
- 8.4. Дотоод мэдээлэл эзэмшигчдэд дараах зүйлийг хориглоно. Үүнд:

- 8.4.1. Дотоод мэдээлэл эзэмшиж буй давуу талаа ашиглан ашиг олох зорилгоор өөрийн болон бусад холбогдох этгээдийн дансаар үнэт цаасыг худалдах, худалдан авах арилжаа хийх;
- 8.4.2. Дотоод мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах, мэдээлэх, эсхүл гуравдагч этгээд Дотоод мэдээллийг олж авах нөхцөлийг бүрдүүлэх;
- 8.4.3. Дотоод мэдээлэл ашиглан үнэт цаас худалдаж авах, худалдахыг гуравдагч этгээдэд зөвлөх, санал болгох;
- 8.4.4. Дотоод мэдээллийг эзэмшиж буй гуравдагч этгээд, өөрийн болон бусад холбогдох этгээдийн дансаар үнэт цаасыг худалдах, худалдан авах, бусдад санал болгох, дотоод мэдээллийг дамжуулах, түүнчлэн дотоод мэдээллийг олж авах нөхцөлийг бүрдүүлэх;
- 8.4.5. Дотоод мэдээлэл эзэмшигч нь Дотоод мэдээлэл эзэмшиж байх хугацаандаа гэрээ, хэлцэл хийж буй Компанийн болон түүний холбогдох этгээдийн үнэт цаасыг худалдах, худалдан авах, мөн түүнчлэн худалдан авах, худалдахыг гуравдагч этгээдэд зөвлөх, ятгах, үнэт цаас гаргагчтай хийж буй гэрээ хэлцлийн талаарх нийтийн хүртээл болоогүй байгаа мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах;
- 8.4.6. Хөрөнгө оруулагчдыг төөрөгдөлд оруулах мэдээллийг нийтийн хүртээл болгох;
- 8.4.7. Дотоод мэдээлэл эзэмшигчид нь Дотоод мэдээллийг нийтийн хүртээл болгохоос өмнө уг мэдээллийг санамсаргүй болон санаатайгаар бусдад дамжуулж, бусдад олж авах нөхцөлийг бүрдүүлэх.

#### **ЕС. ХАРИУЦЛАГА**

- 9.1. Энэхүү Журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхээр төрийн эрх бүхий байгууллагад асуудлыг тавина.
- 9.2. Журмыг зөрчсөн холбогдох ажилтны үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу хөдөлмөрийн сахилгын арга хэмжээ оногдуулна.
- 9.3. Журмыг зөрчсөн ажилтны үйлдэл нь Компанийн эд хөрөнгөд хохирол учруулсан бол түүнд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэж болно.

#### **АРАВ. БУСАД ЗҮЙЛ**

- 10.1. Энэхүү Журмыг Компанийн ТУЗ-өөс батлан гаргасан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
- 10.2. Энэхүү Журмаар зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсын хууль тогтоомж, Компанийн холбогдох дүрэм, журамд заасны дагуу зохицуулна.
- 10.3. Энэхүү Журамд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд ТУЗ-ийн тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулна.
- 10.4. Энэхүү Журмын хэрэгжилтэд Компанийн ТУЗ хяналт тавина.